

Мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл эрхэлж, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах



ТОГТВОРТОЙ НОЛУУРЫН БАТАЛГАА

Бид ноолуураа тогтвортой ноолуурын 25 шалгуур болон түүхий эд ангиллын батлагдсан схемийн дагуу бэлтгэдэг бөгөөд хоршооны гишүүд нь Тогтвортой ноолуур гэрчилгээтэй. Ноолуурын баталгааг шалгах гадны болон дотоод хяналттай. Дотоод хяналтыг хоршооны Бүлэг хариуцсан малчин нь шалгууруудын дагуу хийж, онооны үнэлгээ өгдөг бол Гэрчилгээг аймгийн болон үндэсний хэмжээний Гэрчилгээжүүлэлтийн хороо баталгаажуулж, олгодог.

“ТОГТВОРТОЙ НОЛУУР” ХОЛБОО

“Тогтвортой ноолуур” холбоо нь AVSF Монгол буюу Хил хязгааргүй малын эмч нар ба агрономичид байгууллагын дэмжлэгтэйгээр тогтвортой ноолуур бэлтгэгч хоршоодын санаачилгаар байгуулагдсан бөгөөд ашгийн бус, гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллага юм. Өнөөгийн байдлаар “Тогтвортой ноолуур” Холбоо нь Баянхонгор аймгийн таван хоршооны 350 орчим өрхийн 1600 гаруй малчинтай.



ХОЛБОО БАРИХ:

Хоршооны дарга
Б. Дашзэвэг +976 88588719

Хоршооны Гүйцэтгэх захирал
З. Амартүвшин +976 80118876



ЦАРМЫН ЦАГААН СУВД ХОРШОО

ШИНЭЖИНСТ СУМ,
БАЯНХОНГОР АЙМАГ





ХОРШООНЫ ТАНИЛЦУУЛГА

“Цармын цагаан сувд” Хоршоо нь анх санаа нэгдэн бүх гишүүдийн анхдугаар хурлаа хийж, 2016 оны 3 дугаар сард 42 гишүүнтэйгээр байгуулагдсан. Өдгөө манай хоршоо 63 гишүүнтэй бөгөөд жил бүр гишүүдийнхээ тоог нэмэгдүүлж байна.

Манай хоршоо бэлчээр ашиглагчдын гурван хэсгээс бүрддэг бөгөөд Хоршооны бүтцийн хувьд Хоршооны дарга, нягтлан бодогч, техникч малчин, тэргүүлэгч, хяналтын зөвлөлийн гишүүдтэй. “Цармын цагаан сувд” хоршоо нь “Тогтвортой ноолуур” Холбооны гишүүн бөгөөд манай хоршоо алдарт Залаажинст цагаан ямааны ноолуур бэлтгэгдгээрээ онцлогтой.



ХОРШООНЫ ЗОРИЛГО

Манай хоршооны зорилго мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл эрхэлж, байгалийн тэнцвэрт байдал хадгалж, гишүүдийнхээ амьжиргааг дэмжихийн зэрэгцээ бэлчээрийн зөв зохистой менежментийг хэрэгжүүлэхэд оршино.



ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Цармын цагаан сувд” хоршоо нь малынхаа түүхий эд буюу ноолуурыг байгальд ээлтэй, хоршооны гишүүдэд тэгш хүртээмжтэй, эдийн засгийн шударга хуваарилалттай аргаар бэлтгэн, “Тогтвортой ноолуур” холбоогоор дамжуулан нэмүү өртгөөр борлуулдаг.

“Цармын цагаан сувд” хоршооны гишүүд нь ноолуур борлуулалтын ашгаасаа хоршооны Тогтвортой хөгжлийн санд хуримтлуулж, бэлчээр хамгаалах, фотомониторинг хийх, өвөлжөө хаваржааны хашаа хороог сэргээн засах, шинээр барих, худаг ус сэргээн засварлах зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлдэг.

Хоршооны гишүүд нь бүгд малын эрүүл мэнд, бэлчээрийн зохистой менежментийн сургалтуудад хамрагдаж, нийгэм соёлын харилцаанд орж, хамтран ажиллах дадалтай болсон.

ЦААШДЫН ЗОРИЛТ

Бид цаашид хоршооны гишүүдийн тоо болон ноолуурынхаа хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлд түлхүү анхааран ажиллана.

Мөн захиалагчдынхаа итгэлийг дааж, гэрчилгээжсэн тогтвортой ноолуурыг тогтмол баталгаатай нийлүүлж, аймаг, нутгийнхаа нэр болон Монголын залаажинст цагаан ямааныхаа ноолуурын үнэ цэнийг нэмэгдүүлж, удмын санг нь хадгалж, дотоод, гадаадын хэрэглэгчдэд таниулахад хувь нэмрээ оруулах зорилго тавьж байна.

